



Ариун Сүнс бол . . .

Марисса Виддисон
Сүмийн сэтгүүлүүд




Тэр зүрхэн тус газрыг хучих дулаан **хөнжил** мэт байдаг. Тэр таныг гуниглаж, түгшсэн үед тайтгаруулдаг.




1. **Бурхан Тэргүүтэний нэг гишүүн.** Энэ нь Тэр бидэнд туслахаар Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой хамтран ажилладаг гэсэн үг юм. Түүнд бие махбод гэж байхгүй тул түүнийг заримдаа Сүнс гэж дууддаг.

2. **Баптисмаар дамжин ирдэг бэлэг.** Та уснаас гарсныхаа дараа “гишүүний баталгаа” хэмээх онцгой адислалыг хүлээн авдаг ба таныг Ариун Сүнсийг хүлээн авахад урьдаг.


3. **Тэнгэрлэг Эцэгийн амлалт.** Та ариун ёслолоос хүртэхдээ Есүсийг дагана гэсэн амлалт өгдөг. Тэнгэрлэг Эцэг хариуд нь Ариун Сүнсийг тантай хамт байлгана хэмээн амладаг.




Тэр таныг аюулаас сэрэмжлүүлэх **аюулын дохио** мэт байдаг. Тэр таныг хохироох зүйлсээс хамгаалан, холдуулж чадна.




Тэр зөөлөн **багш** мэт байдаг. Тэр танд юу үнэн болохыг хэлж, сурсан зүйлсээ санахад тань тусална.



Тэр таны үргэлж хамт байхыг хүсдэг **хамгийн сайн найз** шиг байдаг. Та сайн сонголт хийснээр Түүнийг өөртэйгөө хамт байхад урьдаг.



Тэр Тэнгэрлэг Эцэгийн **элч** мэт байдаг. Ариун Сүнс танд Бурханы хайрыг мэдэрч, Түүний таныг мэдээсэй гэж хүсэж байгаа зүйлсийг ойлгоход тусална.



Тэр танд явбал зохих газраа мэдэхэд тань туслах **тэмдэг** мэт байдаг. Сонголт хийхэд тань таныг мөнх амьдралд хүргэх зам дээр үлдэхэд тусална.

СУДРУУД ДЭЭР:

Иохан 14:26
Галат 5:22
2 Нифай 31:17-18
Сургаал ба Гэрээ 130:22